

**Цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийг
кибэр орчинд хууль бусаар халдах гэмт хэргээс
ялган зүйлчлэх асуудалд**

**About Qualification of Fraud Using Electronic
Devices from Illegal Attack in Cyber Environment**

Сугаррагчаагийн Учрал

Хууль зүйн ухааны бакалавр (LL.B.).

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль

Улаанбаатар хот, Монгол Улс

uchrals786@gmail.com

© S.Uchral, 2025



[Attribution-NonCommercial 4.0 International
\(CC BY-NC 4.0\)](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)

[Товч утга]

Орчин үеийн техник, технологийн дэвшил хөгжлийг дагаад “цахим” гэмт хэрэг үйлдэгчдийн тоо жил бүр нэмэгдэж, арга хэлбэр нь илүү боловсронгуй болсоор байгаагийн нэг нь яахын аргагүй “залилах” гэмт хэрэг мөн. Энэ гэмт хэргийн гаралт жил бүр өсөн нэмэгдэхийн зэрэгцээ бусдад учруулах хохирлын хэмжээ нэмэгдэж, нийгмийн хор аюул нь улам бүр ихсэж байна.

Цахим хэрэгсэл ашиглан үйлдэж буй залилах гэмт хэргийг цахим орчинд үйлдэгдэж буй ойролцоо төрлийн гэмт хэрэг болох кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс ялган зүйлчлэх шаардлагатай байна. Ялангуяа, нэг үйлдэл нь тус гэмт хэргүүдийн шинжийг агуулж байгаа тохиолдолд хэрхэн ялган зүйчлэхийг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжээр болон өрсөлдөх хэм хэмжээний онолын үүднээс авч үзлээ. Тус гэмт хэргүүдийг ялган зүйлчлэхгүй тохиолдолд гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэмжээ, шинж чанар, гэм буруугийн хэлбэрт тохироогүй эрүүгийн хариуцлага оногдуулж, Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчим хэрэгжихгүйд хүрнэ.

[Түлхүүр үг]

Гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж, сэдэлт, зорилго, өрсөлдөх хэм хэмжээ, нийлмэл гэмт хэрэг, шударга ёсны зарчим.

I. Оршил

Монгол улс, тэр дундаа иргэний эрх зүйн харилцаанд оролцогч цахим хэлцлийг хийх боломж 1994 оноос эхэлж бүрдсэн бөгөөд мэдээллийн технологи асар хурдтай хөгжил нь хүний хөдөлмөрийг хөнгөлөх, цаг хугацааг хэмнэх зэрэг олон талын ач холбогдолтой ч түүнийг сөргөөр буюу гэмт хэрэг үйлдэх нэг хэрэгсэл болгох явдал есөн нэмэгдэж байна. Орчин үеийн техник, технологийн дэвшил хөгжлийг дагаад “цахим” гэмт хэрэг үйлдэгчдийн тоо жил бүр нэмэгдэж, арга хэлбэр нь илүү боловсронгуй болсоор байна.

Практикт цахим орчинд адил төстэйгөөр үйлдэгдэж буй ойролцоо төрлийн гэмт хэргүүд болох Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хуульчлагдсан “Залилах (цахим хэрэгсэл ашиглаж залилах)” гэмт хэрэг болон 26.1 дүгээр зүйлд хуульчилсан “Кибер орчинд хууль бусаар халдах” гэмт хэргүүдийг ялган зүйлчлэх асуудал маргаантай байна. Мөрдөн байцаалт, шүүхийн практикаас харахад залилах гэмт хэрэг нь дараах арга хэлбэрээр голчлон илэрч байна. Үүнд:...Иргэдийн цахим шуудан, фэйсбүүк хаягт хууль бусаар нэвтрэн, тэдний нэрээр ойр дотнын найз нөхөд, ах дүү нарт нь мөнгөний яаралтай хэрэгцээ гарсан мэтээр тусламж гуйн мөнгө шилжүүлж авах...” зэрэг үйлдлийн аргуудаар түгээмэл илэрдэг.¹ Энэ тохиолдолд практикт гэмт хэргийг нэг бол “Залилах” гэмт хэргээр зүйлчлэх, эсхүл хоёр гэмт хэргээр зүйлчлэх асуудал байгаа бөгөөд тус гэмт хэргүүдийн аль аль шинжийг хангаж байгаа тохиолдолд өрсөлдөгч хэм хэмжээ юу, нийлмэл гэмт хэрэг үү гэдгийг тодорхойлж зүйлчлэлийг оновчтой хийх шаардлагатай байна. Зөвхөн “Залилах” гэмт хэргээр зүйлчлэх үйлдлийг 2 гэмт хэрэг үйлдсэн гэж дүгнэн ял оноосноор эрүүгийн эрх зүйн шударга ёсны зарчим алдагдахад хүрнэ.

Тус өгүүлээр цахим хэрэгсэл ашиглаж залилах болон кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэргийн зүйлчлэлийн асуудлыг болон түүний учир холбогдлыг онолын болон практикийн үүднээс танин мэдэхүйн шинжлэх ухааны нийтлэг арга болох баримт бичиг судлалын арга, анализ, синтез, кейс судлал, харьцуулалтын аргуудыг ашиглаж судаллаа.

Залилах гэмт хэргийн болон цахим гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн асуудлаар магистрын, бакалаврын түвшинд болон эрдэм шинжилгээний өгүүлэл зэрэг тодорхой судалгаанууд хийгдэж байсан. Зүйлчлэлийн хувьд иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэх асуудлыг тусгайлан судалсан байна. Тэдгээр судалгаануудад эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй

¹ Нээлттэй нийгэм форум, *Шүүхийн шийдвэрийн судалгаа-Цуврал 2*, (2022).

болгох асуудлыг л хөндөж гаргаснаас бус хэрхэн зөв зүйлчлэлийг хийж, хэрхэн хуулиа хэрэглэх талаар хууль хэрэглээний асуудлыг хөндөөгүй. Өөрөөр хэлбэл, цахим хэрэгсэл ашиглаж үйлдэгдэх залилах гэмт хэргийг кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэргээс хэрхэн ялгах, түүний учир холбогдлын талаар бие даасан, тусгайлан судалсан бүтээл төдийлөн байхгүй байна. Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал чухал хэдий ч бид юун түрүүнд нэгэнт хуульчлагдан зохицуулагдсан зохицуулалтын хүрээнд хуулиа зөв хэрэглэх асуудал мөн чухал юм.

Иймд энэхүү өгүүллээр практикт адил үйлдлээр илэрч байгаа гэмт хэргийг өөр өөр байдлаар зүйлчлэн ял оногдуулж байгаа сүүлийн жилүүдэд түгээмэл үйлдэгдэж буй гэмт хэргийг сонгон судалж, ялган зүйлчлэхэд баримтлах онолын асуудлыг практикт зөв бөгөөд бүрэн хэрэгжүүлэх, зүйлчлэлийг оновчтой хийж улмаар эрүүгийн эрх зүйн шударга ёсны зарчмыг хангахыг сануулж, уриалахыг зорилоо.

II. Гэмт хэргийн бүрэлдэхүүн

Гэмт хэргийн зүйлчлэлийг оновчтой зөв хийж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тохирсон ял оногдуулахад гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг зөв тогтоон задлан шинжлэх нь чухал. Гэмт хэргийн бүрэлдэхүүний элемент нь эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бүх гэмт хэргүүдийн хувьд заавал байх тодорхой шинжүүдээр тодорхойлогдох, харьцангуй бие даасан бүрдэл хэсэг юм. Дөрвөн элемент бүхий гэмт хэргийн бүрэлдэхүүний онолоор гэмт хэргийн бүрэлдэхүүн нь заавал байх объект,объектив тал,субъект, субъектив тал гэсэн бүрдэл хэсгээс тогтоно.² Гэмт хэрэг нь өөрийн гэсэн бүрдлийн элементтэй ба тэдгээр нь бүрэн хангагдаж байж сая гэмт хэрэг, ялын ойлголт бий болно.³ Эдгээр элементүүд нь гэмт хэргийн төрөл, шинжийг ялган харуулах гол шалгуур болох ба аль нэг элемент нь байхгүй буюу хангагдаагүй үед эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл үгүйсгэгдэнэ.⁴ Иймд цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэрэг болон кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэргүүдийг зөв зүйлчлэхийн тулд бүрэлдэхүүний шинжийг танин мэдэх шаардлагатай.

A. Цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж, онцлог

ЭХТА-н 17.3 дугаар зүйлд “Залилах” гэмт хэргийг хуульчилсан.

² Галбатын Гантөмөр, *Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол*, (Улаанбаатар: 2011).

³ Тогоогийн Золбоо, *Эрүүгийн эрх зүй: Гэмт хэргийн бүтээц*, (Улаанбаатар: 2016), 37 дахь тал.

⁴ Тогоогийн Золбоо, *өмнөх ишлэл* 3, 39-40 дэх тал.

Тус гэмт хэргийн ердийн бүрэлдэхүүнд “хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан. Үндсэн гэмт хэрэг нь “залилах”. “Цахим хэрэгсэл ашиглаж” гэдэг нь тус залилах гэмт хэргийг үйлдэж болох аргуудын нэг нь байна. Иймд үндсэн “Залилах” гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг авч үзье.

Гэмт хэргийн объектив шинжийн хувьд гэмт хэргийн объект нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашиг болох бусдын өмчлөх эрх байдаг бол халдлагын зүйл нь залилагдсан эд хөрөнгө байдаг. Харин гэмт хэргийн объектив тал нь залилах гэмт үйлдлийн гадаад шинж бөгөөд тухайн зүйлийн диспозицид тодорхой тусгагдсан, гэмт хэргийн бүрэлдэхүүний хамгийн чухал элемент мөн. Залилах гэмт хэргийн хувьд бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан идэвхтэй үйлдэл байдаг. 2015 оны ЭХ-н 17.3 дугаар зүйлд “Залилах” гэмт хэргийн диспозицид хуульчилсан хуурч, баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж зэрэг аргууд нь тус гэмт хэргийн объектив талыг тодорхойлно. “Цахим хэрэгсэл ашиглаж залилах” аргын тухайд “e-mail, message бичиж илгээх, интернэт худалдаа хийх нэрээр өөр компани, хүний нэрийн өмнөөс харилцаж, өөрийн данс руу мөнгө шилжүүлэн авах, эзнийг хуурч авсан банкны карт, пин кодыг ашиглан АТМ-ээс мөнгийг авах... зэрэг цахим хэрэгслээр дамжуулан хуурч мэхэлсэн үйлдлүүдийн үр дүнд эд хөрөнгөө шилжүүлж өгсөн байх”⁵ гэж тайлбарласан. Тус цахим хэрэгсэл ашиглаж байгаа арга нь “Залилах” гэмт хэргийг үйлдэх нэгэн арга мэт боловч өөртөө уламжлалт аргууд болох хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж гэх аргуудыг багтаасан буюу тухайн аргуудыг ашиглаж цахим орчинд үйлдэж байгаагаараа онцлогтой бөгөөд энэ нь тус гэмт хэргийн объектив талын онцлогийг тодорхойлж байна. Залилах гэмт хэргийг хохирлын хэмжээ шаардахгүй буюу хэлбэрийн

⁵ Хяраадайн Доржпалам, *Монгол улсын эрүүгийн эрх зүй: Тусгай анги*, (Улаанбаатар: 2021), 115-116 дахь тал.

шинжтэйгээр хуульчилсан. Өөрөөр хэлбэл, хуульд заасан аргаар бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авснаар энэ гэмт хэрэг төгсөнө. Тус үйлдлийн улмаас хохирол, хор уршиг учирсан байхыг шаардахгүй.

Гэмт хэргийн субъектив шинжийн хувьд гэмт хэргийн субъект нь 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд байдаг. Харин гэмт хэргийн субъектив тал нь гэм буруугийн санаатай хэлбэр байна. Залилагчид нь хүний хэрэгцээнд тулгуурлан амар хялбар аргаар мөнгө олох гэсэн сэдэлтэй байдаг. Гэмт этгээд хэн болох нь тодорхойгүй, ихэвчлэн нууц нэр, нэргүйгээр цахим орчинд гэмт хэрэг үйлддэг. Мөн бусдын эд хөрөнгийг шилжүүлэн авахдаа өөрийн дансаар бус өөр хүний дансаар авах зэргээр өөрийгөө нууцлах, илчлэгдэхгүй байх санаа, зорилгыг агуулдаг нь субъектив талын онцлог шинж юм.

Цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэрэг нь “Залилах” гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний шинжийг өөртөө агуулсан, цахим гэмт хэргийн онцлог шинжийг мөн багтаасан байдгаараа онцлогтой. Уламжлалт аргаар үйлдэгддэг залилах гэмт хэргээс хэд дахин илүү хурдан хугацаанд, олон хохирогчийг хамарч, их хохирол учруулж, нууцлагдмал, илрүүлэхэд хүндрэлтэйгээр үйлдэгддэг гэмт хэрэг юм.

Б. Кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж

Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэгт “Кибер орчинд хууль бусаар халдах” гэмт хэргийг хуульчилсан. Тус гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг авч үзье.

Объектив шинжийн хувьд гэмт хэргийн объект нь мэдээлэл, мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний аюулгүй байдал бөгөөд халдлагын зүйл нь мэдээлэл, мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ байна. Харин гэмт хэргийн объектив тал нь тус гэмт хэргийн диспозицид хуульчилсан Кибер орчинд зөвшөөрөлгүйгээр хандаж мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд нэвтэрсэн, танилцсан үйлдэл, Кибер орчинд хууль бусаар халдаж мэдээллийг устгасан, гэмтээсэн, өөрчилсөн, засварласан, нуусан, нэмж оруулсан, хуулбарлаж авсан, ашиглах боломжгүй болгосон, Кибер орчинд хууль бусаар халдаж мэдээллийн систем, мэдээллийн сүлжээг ашиглах боломжгүй болгосон, хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан, хандалтад хязгаарлалт тогтоосон, ноцтой саад учруулсан зэрэг үйлдлүүд байна. Тус гэмт хэргийг хохирлын хэмжээ шаардахгүй буюу хэлбэрийн шинжтэйгээр хуульчилсан. Өөрөөр хэлбэл, зөвшөөрөлгүйгээр мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд нэвтэрсэн, танилцсанаар, мэдээллийг устгаснаар, гэмтээснээр гэх мэтээр гэмт хэргийн диспозицид заасан үйлдэл хийснээр энэ гэмт хэрэг төгсөнө. Тус

үйлдлийн улмаас хохирол, хор уршиг учирсан байхыг шаардахгүй.

Субъектив шинжийн хувьд гэмт хэргийн субъект нь 14 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд байдаг. Гэмт хэргийн субъектив тал нь гэм буруугийн санаатай хэлбэр байна.

III. Гэмт хэргийн зүйлчлэл

A. Гэмт хэргийн зүйлчлэлийн ойлголт

Гэмт хэргийн зүйлчлэл гэж тухайн этгээдийн үйлдсэн нийгэмд аюултай хэрэг Эрүүгийн хуулийн тусгай ангийн тодорхой хэм хэмжээнд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх шинжтэй нарийн нийцэж байгааг тогтоох ба байцаан шийтгэх ажиллагаанд бэхжүүлэх явдал мөн.⁶ Эрүүгийн хуулийн тусгай ангид өөр хоорондоо ойролцоо, бие биетэйгээ төсөөтэй гэмт хэргийн бүрэлдэхүүн цөөнгүй бөгөөд тэдгээр гэмт хэргийг зааглан ялгах нь зүйлчлэлийн бие даасан чухал үе шат юм.⁷ Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шударга, ялгамжтай, тохирсон ял ногдуулах нэн чухал урьдач нөхцөл нь гэмт хэргийг зөв зүйлчилсэн байх явдал мөн.⁸ Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэргийг эрүүгийн хуулийн ямар зүйлээр зүйлчлэв гэдгээс ямар ял ногдуулах асуудал шууд шалтгаална.⁹ “Тодорхой хэргийг буруу зүйлчилснээс болж нэг талаар хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэргийг нийгмийн аюулаар их биш гэмт хэргээр зүйлчлэх боломж нөхцөлийг буй болгоно. Ингэснээр гэм буруутай этгээд хуулийн дагуу хүлээх байсан ялаас үлэмж хөнгөн хариуцлага хүлээхийн зэрэгцээ хангалттай үндэслэлгүй байхад түүний үйлдсэн хэрэгт улс төр, хууль зүй, ёс суртахууны дэндүү хөнгөн үнэлэлт өгөхөд хүргэнэ. Нөгөө талаар нийгмийн хор аюулаар их биш гэмт хэргийг хүнд гэмт хэргээр зүйлчлэх буюу эсвэл эрхзүйн өөр зөрчил байхад гэмт хэрэг гэж үзэх нь шүүн таслах асуудлыг хариуцсан төрийн байгууллага, тэдгээрийн ажилтны нэр хүндийг сулруулах төдийгүй гэм буруутай этгээдийг хэт хатуу шийтгэх буюу эсвэл гэм буруугүй хүнийг хилсээр эрүүгийн хариуцлагад татах нөхцөлийг буй болгоно.”¹⁰

Б. Цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэргийг кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэргээс ялган зүйлчлэх нь

Цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэрэг болон кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэргүүд нь субъектив шинжийн гэм буруугийн

⁶ Содовсүрэнгийн Нарангэрэл, *Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс (онол, практик)*, (Улаанбаатар: 1988).

⁷ Содовсүрэнгийн Нарангэрэл, *Монгол улсын эрүүгийн эрх зүй: Тусгай анги*, (Улаанбаатар: 1998), 8 дахь тал

⁸ Содовсүрэнгийн Нарангэрэл, *Өмнөх эшлэл 6*, 19 дэх тал.

⁹ *Мөн тэнд.*

¹⁰ Содовсүрэнгийн Нарангэрэл, *Өмнөх эшлэл 6*, 19-20 дахь тал.

санаатай хэлбэрээр үйлдэгддэгээрээ ижил төстэй. Гэхдээ субъектив шинжийн нэмэлт элемент болох зорилгоороо ялгагдах боломжтой. Тухайлбал, залилах гэмт хэргийг үйлдэгчийн гол санаа зорилго нь бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авах байдаг. Харин кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэргийг үйлдэгчийн санаа зорилго нь бусдын мэдээлэл, мэдээллийн сүлжээ, мэдээллийн системд халдах байдаг. Мөн бусад 3 шинжээр ялгагдахаар харагдаж байна. Тухайлбал, залилах гэмт хэргийн объект нь бусдын өмчлөх эрх байдаг бол кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэргийн объект нь мэдээллийн аюулгүй байдал байна. Залилах гэмт хэргийн субъект нь 16 насанд хүрсэн этгээд байдаг бол кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэргийн субъект нь 14 насанд хүрсэн этгээд байдаг. Мөн тухайн гэмт хэргүүдийн объектив шинж болох гэмт хэргийн диспозицид хуульчилсан үйлдлүүд, үйлдлийн аргуудаараа ялгагдана. Тус гэмт хэргүүдийг ямар тохиолдолд ялган зүйлчлэх шаардлага гарч байгааг жишээнээс тодруулж, бүрэлдэхүүний шинжээр харьцуулан үзье.

Жишээ 1:

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 1329 дугаар шийтгэх тогтоолоос¹¹: Шүүгдэгч Г.Ц. нь 2022 оны 03 дугаар сарын 17-18-ны өдрийн хооронд иргэн Л.Батхуягийн “Lusvan Batkhuyag” гэх фейсбүүк хаягт хууль бусаар халдаж, түүний фейсбүүк хаягийн нэвтрэх нууц үг мэдээллийг өөрчлөн, улмаар тус фейсбүүкийн найзууд руу “мөнгө зээлээч” гэсэн зурвас илгээж, бодит байдлыг нуух замаар төөрөгдөлд оруулан хуурч, 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Хаан банкны Н.Жавзанпагма гэх эзэмшигчтэй 5724123990 дугаарын дансаар иргэн Л.Эрдэнэбилэгээс 500.000 төгрөгийг, Т.Бүрэнбатаас 500.000 төгрөгийг, Д.Алдараас 400.000 төгрөгийг, Н.Түмэндэлгэрээс 300.000 төгрөгийг шилжүүлэн авсан. Шүүхээс залилах гэмт хэргийн “цахим хэрэгсэл ашиглаж” гэх хэм хэмжээ, кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэрэг зэрэг нь үйлдлийн арга, санаа зорилгоороо ялгагдаж байх бөгөөд дан ганц хэрэглэгчийн мэдээллийг хууль бусаар өөрчилсөн нь Эрүүгийн хуулийн 26.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг хангасан гэж үзсэн. Улмаар шүүгдэгч Г.Ц-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “залилах” гэмт хэрэг 26.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “Кибер орчинд хууль бусаар халдах” гэмт хэрэг тус тус үйлдсэн гэж үзсэн.

¹¹ Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн, 2023 оны 10 сарын 26-ны өдрийн 2023/ЛШЦТ/1329 шийтгэх тогтоол, https://shuukh.mn/single_case/94972?daterange=2023-01-01%20-%202023-12-04&id=1&court_cat=2&bb=1.

Жишээ 2:

Дорноговь аймаг дахь сум дундын анхан шатны шүүх /эрүүгийн хэрэг/-ийн 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 2022/ШЦТ/44 дугаар шийтгэх тогтоолоос¹²: Шүүгдэгч Б.Б нь 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Дорноговь аймгийн Сайншанд сумын 2 дугаар баг, Энхтайваны гудамжны 02-12 тоотод оршин суух О.Сайханбилэгийн фейсбүүк цахим хэрэгсэлд хууль бусаар нэвтэрч, цахим хаягийг нь ашиглаж, бодит байдлыг нуух замаар төөрөгдөлд оруулж, “маргааш болтол мөнгө зээлүүлээч” гэж хохирогч А.Баас 50,000 төгрөг, хохирогч Б.Баас 30,000 төгрөгийг тус тус Хаан банкны тоот дансанд шилжүүлэн авсан. Шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “бусдыг хуурч цахим хэрэгсэл ашиглаж, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгийг шилжүүлэн авч залилах” гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцсон.

Дээрх хоёр тохиолдолд фейсбүүк цахим хэрэгсэлд хууль бусаар нэвтэрч, залилах гэмт хэрэг үйлдсэн ижил үйлдэл бүхий хоёр тохиолдолд өөр өөр байдлаар ял оногдуулсан байна. Иймд юун түрүүнд жишээ 1-ийн зүйлчлэлийг авч үзэж, гэмт хэргийн бүрэлдэхүүний онолын үүднээс Г.Ц-ийн үйлдэлд дүн шинжилгээ хийж үзье.

	Цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж	Кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэрэг	Бусдын фейсбүүк хаягийн нэвтрэх нууц үг мэдээллийг өөрчлөн, улмаар тус фейсбүүкийн найзууд руу “мөнгө зээлээч” гэсэн зурвас илгээж, бодит байдлыг нуух замаар төөрөгдөлд оруулан хуурч мөнгө шилжүүлэн авсан үйлдэл
Объект	Бусдын өмчлөх эрх	М э д э э л л , мэдээллийн систем, м э д э э л л и й н сүлжээний аюулгүй байдал	Мөнгөө алдсан иргэдийн өмчлөх эрх (фейсбүүк хаягт нэвтрэх мэдээллээ алдсан иргэдийн мэдээллийн аюулгүй байдал байж болно)

¹² Дорноговь аймаг дахь сум дундын анхан шатны шүүх /Эрүүгийн хэрэг/-ийн 2022 оны 03 сарын 09-ны өдрийн 2022/ШЦТ/44 шийтгэх тогтоол, https://shuukh.mn/single_case/64814?daterange=2020-01-01%20-%202022-12-01&id=1&court_cat=2&bb=1.

<p>Объектив тал</p>	<p>хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далмдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан</p>	<p>Кибер орчинд зөвшөөрөлгүйгээр хандаж мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд нэвтэрсэн, танилцсан үйлдэл, Кибер орчинд хууль бусаар халдаж мэдээллийг устгасан, гэмтээсэн, өөрчилсөн, засварласан, нуусан, нэмж оруулсан, хуулбарлаж авсан, ашиглах боломжгүй болгосон, Кибер орчинд хууль бусаар халдаж мэдээллийн систем, мэдээллийн сүлжээг ашиглах боломжгүй болгосон, хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан, хандалтад хязгаарлалт тогтоосон, ноцтой саад учруулсан зэрэг үйлдэл</p>	<p>Хуурч, цахим хэрэгсэл ашиглаж, бодит байдлыг нуух замаар төөрөгдөлд оруулж өмчлөгчийн эд хөрөнгийг шилжүүлэн авсан. (кибер орчинд зөвшөөрөлгүйгээр хандаж мэдээллийг өөрчилсөн үйлдэл байж болно)</p>
<p>Субъектив тал</p>	<p>Гэм буруугийн санаатай хэлбэр Зорилго нь бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авах</p>	<p>Гэм буруугийн санаатай хэлбэр Зорилго нь мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд нэвтрэх, танилцах, Кибер орчинд хууль бусаар халдаж мэдээллийг устгах, гэмтээх, өөрчлөх, засварлах, нуух, нэмж оруулах, хуулбарлаж авах, ашиглах боломжгүй болгох, мэдээллийн систем, мэдээллийн сүлжээг ашиглах боломжгүй болгох, хэвийн үйл ажиллагааг алдагдуулах,</p>	<p>Гэм буруугийн санаатай хэлбэр Зорилго нь бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авах (тус үйлдлийг хийхийн тулд фейсбүүк хаягт нэвтрэх мэдээллийг өөрчлөх байж болно)</p>

		х а н д а л т а д хязгаарлалт тогтоох, ноцтой саад учруулах зэрэг байна.	
Субъект	16 насанд хүрсэн субъект	14 насанд хүрсэн субъект	Г.Ц (20 настай)

Г.Ц-ийн гэмт хэрэг үйлдэх сэдэлт, зорилго нь анхнаасаа бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авах байсан. Тэрээр цахим орчинд хууль бусаар халдаж иргэний фейсбүүкийн мэдээллийг өөрчилсөн ч гэмт хэрэг үйлдэх анхны сэдэлт, зорилго нь тус мэдээллийг өөрчлөхөд чиглээгүй. Харин бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авахын тулд ашигласан арга нь бусдын фейсбүүкийн мэдээллийг өөрчлөх байсан. Тэгэхээр анхнаасаа ямар сэдэлт, зорилгоор гэмт хэрэг үйлдэх болсон бэ гэдэг нь гэмт хэргийг ялган зүйлчлэхэд мөн чухал байна.

Дээрх харьцуулалтаас үзэхэд Г.Ц-ийн үйлдэл нь аль аль гэмт хэргийн шинжийг хангаж болохоор харагдаж байна. Энэ тохиолдолд Г.Ц-ийн дээрх үйлдэл нь өрсөлдөгч хэм хэмжээнд хамаарах уу? Нэг үйлдэлт нийлмэл гэмт хэрэг үү? гэх асуудалд шийдэл олох шаардлагатай болж байна. Шүүн таслах ажлын практикт нэг үйлдэлтэй нийлмэл гэмт хэргийг эрүүгийн эрх зүйн өрсөлдөгч хэм хэмжээнээс ялгахад нэлээд бэрхшээл тулгардаг. Нийлмэл гэмт хэрэг нь эрүүгийн хуулийн тусгай ангийн өөр өөр зүйлд заасан хоёр буюу түүнээс дээш гэмт хэрэг байдаг бол өрсөлдөгч хэм хэмжээний үед нэг гэмт хэрэг байна.¹³ Эрүүгийн эрх зүйн өрсөлдөгч хэм хэмжээ гэдэгт нэг хэрэг эрүүгийн хуулийн тусгай ангийн хэд хэдэн зүйлд нэгэн зэрэг хамаарагдах бөгөөд тэдгээрээс аль нэгийг нь сонгох тохиолдлыг ойлгож иржээ.¹⁴ Нийлмэл гэмт хэрэг нь гэм буруутай этгээд янз бүрийн цаг хугацаанд нийгэмд аюултай бие даасан хэд хэдэн үйлдэл (эс үйлдэл)-ээр хэд хэдэн гэмт хэрэг үйлдэх, түүнчлэн нийгэмд аюултай нэг үйлдэл (эс үйлдэл)-ээр хоёр буюу түүнээс дээш гэмт хэрэг үйлдэх замаар илрэн гардаг юм. Үүнтэй холбогдуулан нийлмэл гэмт хэргийг нэг буюу хэд хэдэн үйлдэлтэй нийлмэл гэмт хэрэг гэсэн хоёр төрөлд ангилна. Нийгэмд аюултай нэг үйлдэл (эс үйлдэл)-ээр эрүүгийн хуулийн хоёр буюу түүнээс дээш өөр зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэнийг нэг үйлдэлт нийлмэл гэмт хэрэг гэнэ.¹⁵ Хэрэв Г.Ц-ийн үйлдлийг өрсөлдөгч хэм хэмжээ гэж үзвэл зөвхөн нэг гэмт хэрэг буюу “цахим хэрэгсэл ашиглаж залилах” гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ. Харин нэг үйлдэлт нийлмэл гэмт хэрэг гэж үзвэл “Цахим

¹³ Содовсүрэнгийн Нарангэрэл, *Өмнөх эшлэл 6*, 190 дэх тал.

¹⁴ *Мөн тэнд*

¹⁵ Содовсүрэнгийн Нарангэрэл, *Өмнөх эшлэл 6*, 179 дэх тал.

хэрэгсэл ашиглаж залилах” гэмт хэргийг “Кибер орчинд хууль бусаар халдах” гэмт хэрэгтэй давхар зүйлчлэх юм.

Үүнийг онолын үүднээс авч үзвэл судлаач, доктор Т.Золбоо нь “Гэмт хэргийн бүтээц” номдоо тодорхойлсноор “Субъект хэд хэдэн гэмт хэргийн бүрдлийг зэрэгцэн бий болгосон тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хэрхэн оноох тухай асуудал үүсдэг. Онолын хувьд энэ асуудлыг Хуримтлах, Шингээх, Хамтатгах гэсэн гурван зарчмын үндсэн дээр зохицуулж байна. Хуримтлах зарчим нь гэмт хэргийн ялыг нэг бүрчлэн нэмэх утгыг агуулах бол шингээх зарчим нь субъект хоёр тусдаа гэмт хэргийн шинжийг бий болгосон боловч хууль тогтоогч хөнгөн гэмт хэргийг хүнд гэмт хэрэгт шингээн нэг гэмт хэрэг болгон хуульчилсан байхыг хэлдэг. Хамтатгах зарчим нь гэмт хэрэг болгонд тус тусдаа эрүүгийн хариуцлага хүлээлгэх боловч, тэдгээр ялыг хооронд нь нэмэхгүй. Харин хөнгөн гэмт хэргийн хамгийн өндөр ялтай гэмт хэрэгт багтаан нэг л ял оноох утгыг агуулдаг.”¹⁶

Үүнээс үзэхэд кибер орчинд хууль бусаар халдаж мэдээллийг өөрчилсөн үйлдэл болон Хуурч, цахим хэрэгсэл ашиглаж, бодит байдлыг нуух замаар төөрөгдөлд оруулж өмчлөгчийн эд хөрөнгийг шилжүүлэн авсан үйлдлүүд нь өөр өөр гэмт хэргийн шинжийг бий болгож байгаа хэдий ч хууль тогтоогч шингээх зарчмын дагуу цахим орчинд хууль бусаар халдаж мэдээллийг өөрчилсөн шинжийг залилах гэмт хэрэгт шингээн “цахим хэрэгсэл ашиглаж залилах” гэж хамт зохицуулж өгсөн гэж үзэж болохоор байна.

Иймд Г.Ц-ийн үйлдлийг өрсөлдөх хэм хэмжээнд хамааруулан ойлгож болохоор байх тул нэг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж “Залилах” гэмт хэргээр зүйлчлэх үндэслэлтэй байжээ. Харин Жишээ 2-т дурдсан Б.Б-ийн үйлдлийг шүүхээс зөв зүйлчлэн ял оногдуулсан гэж үзэхээр байна.

IV. Гэмт хэргүүдийг ялган зүйлчилсний учир холбогдол

Шүүгдэгч Г.Ц-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 1 жил 6 сарын хугацаагаар хорих ял, 26.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 1 жил 6 сарын хугацаагаар хорих ял оногдуулсан.

Хэрэв Г.Ц-ийн үйлдлийг зөвхөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Залилах” гэмт хэрэгт тооцож ял оногдуулсан бол 1 жил 6 сарын хугацаагаар хорих ял шийтгүүлэх байжээ.

Эрүүгийн хуульд “шударга ёсны зарчим”-ыг хуульчилсан байдаг. Шударга ёсны зарчмын агуулгад “Эрүүгийн хариуцлага нь

¹⁶ Тогоогийн Золбоо, *өмнөх эшлэл* 3, 176-177 дахь тал.

тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэх болон “Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэх ойлголт хамаардаг. Хэдий эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршдог ч тус зорилгыг хангана гээд шударга ёсны зарчмын хэрэгжилтийг алдагдуулж болохгүй.

Гэмт хэргийг зөв, оновчтой зүйлчилснээр эрүүгийн хариуцлагыг оновчтой, тохиромжтой, шударгаар оногдуулах нөхцөл бүрдэнэ. *Гэмт хэргийн зүйлчлэлийг зөв хийгээгүйгээс шударга ёсны зарчмын агуулга алдагдахад хүрэх юм.* Дээрх жишээнээс үзэхэд Г.Ц-ийн үйлдэлд ял оногдуулсан байдал нь эрүүгийн хариуцлага нь түүний гэм буруугийн хэлбэрт тохирсон байна, нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна гэх эрүүгийн хариуцлагын шударга ёсны зарчмын агуулга алдагдахад хүрчээ.

Мөн ижил үйлдлийн аргаар үйлдэгдсэн хоёр тохиолдолд шүүхээс хоёр өөр байдлаар ял оногдуулж байгаа нь иргэдийн цагдаа, шүүх, прокурор зэрэг хууль хяналтын байгууллагад итгэх итгэлийг сулруулах, тэдний нэр хүндэд сөргөөр нөлөөлөх зэрэг дам сөрөг нөлөөтэй билээ.

V. Дүгнэлт

Техник, технологи хөгжихийн хэрээр цахим буюу кибер гэмт хэргийн гаралт өсөж, гэмт хэрэг үйлдэх арга, хэлбэр нь нарийсаж байна. Үүнтэй холбоотойгоор ойролцоо арга, хэлбэрээр цахим орчинд үйлдэгдэх цахим буюу кибер гэмт хэргүүдийг ялган оновчтой зүйлчлэх асуудал тулгарч байгаа юм. Энэ тохиолдолд шүүх, прокуророос гэмт хэргийг ялган зүйлчлэхдээ онол, практикийг хослуулж дүн шинжилгээ хийх нь зүйтэй.

Тус өгүүлээр нэг хэрэг эрүүгийн хуульд заасан хэд хэдэн гэмт хэргийн шинжийг хангаж байгаа бол онолын үүднээс хэрхэн задлан шинжилж, зүйлчлэхийг “Цахим хэрэгсэл ашиглаж үйлдэх залилах” болон “Кибер орчинд хууль бусаар халдах” гэмт хэргийн жишээн дээр авч үзлээ.

Ойролцоо төрлийн гэмт хэргүүдийг зүйлчлэхдээ гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжээр ялган үзэж, гэмт хэрэг үйлдэх анхны сэдэлт, зорилгыг тодруулах нь зүйтэй. Улмаар гэмт үйлдэл нь хэд хэдэн гэмт хэргийн шинжийг агуулж байгаа бол өрсөлдөх хэм хэмжээний онолын үүднээс дүгнэх юм.

Гэмт хэргийг хэрхэн зүйлчлэхээс шалтгаалан Эрүүгийн хуульд заасан “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна”, “Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэх шударга ёсны зарчмын хэрэгжилт хангагдаж байгаа байдал нь тодорхойлогдох юм. Улмаар иргэдийн цагдаа, шүүх, прокурор зэрэг хууль хяналтын байгууллагад итгэх итгэлийг алдагдуулахгүй байх, тэдний нэр хүндэд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх ач холбогдолтой билээ.

[Ном зүй]

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн, 2023 оны 10 сарын 26-ны өдрийн 2023/ШЦТ/1329 шийтгэх тогтоол, https://shuukh.mn/single_case/94972?daterange=2023-01-01%20-%202023-12-04&id=1&court_cat=2&bb=1.

Дорноговь аймаг дахь сум дундын анхан шатны шүүх /Эрүүгийн хэрэг/-ийн 2022 оны 03 сарын 09-ны өдрийн 2022/ШЦТ/44 шийтгэх тогтоол, https://shuukh.mn/single_case/64814?daterange=2020-01-01%20-%202022-12-01&id=1&court_cat=2&bb=1.

Галбатын Гантөмөр, *Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол*, Улаанбаатар: 2011 он.

Нээлттэй нийгэм форум, Шүүхийн шийдвэрийн судалгаа-Цуврал 2, 2022 он. Содовүрнгийн Нарангэрэл, *Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс (онол, практик)*, Улаанбаатар: 1988 он.

Содовсүрэнгийн Нарангэрэл, *Монгол улсын эрүүгийн эрх зүй: Тусгай анги*, Улаанбаатар: 1998 он.

Тогоогийн Золбоо, *Эрүүгийн эрх зүй: Гэмт хэргийн бүтээц*, Улаанбаатар: 2016 он.

Хяраадайн Доржпалам, *Монгол улсын эрүүгийн эрх зүй: Тусгай анги*, Улаанбаатар: 2021 он.

[Abstract]

**About Qualification of Fraud Using Electronic Devices
from Illegal Attack in Cyber Environment**

Uchral Sugarragchaa

Bachelor of Laws (LL.B.).

School of Law, National University of Mongolia

Ulaanbaatar, Mongolia

With the development of modern techniques and technology, the number of “electronic” criminals is increasing every year, and the methods are becoming more sophisticated, one of which is undoubtedly “fraud”. The incidence of this crime is increasing every year, along with the amount of damage it causes to others, and the danger to society is increasing more and more.

Fraud crimes committed using electronic means should be distinguished from cyber security crimes, which are similar crimes committed in the online environment. In particular, in the case that one act contains the characteristics of these crimes, how to distinguish them from the elements of the crime and from the perspective of the theory of competing norms. If these crimes are not differentiated, criminal responsibility will be imposed that does not match the level of social danger of the crime, nature, and form of guilt, and the principle of justice of the Criminal Law will not be implemented.

[Keywords]

Constituent Elements of the crime, Motivation, The Purpose of the crime, Competition of Criminal law norms, Compound crime, Principle of justice of the Criminal Law.